



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.11 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүний нөөцийн бодлого, төсөв санхүүгийн ил тод байдлыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар тухай бүр шинэчлэн байрлуулах ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн мэдээллийг боловсруулж, хянуулан цахим хуудас болон мэдээллийн самбартаа байрлуулах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (П.Туул)-д даалгасугай.

3. Ажлын хэсгийн ажлыг ерөнхий удирдлага зохицуулалтаар хангаж, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэбат)-д даалгасугай.

ДАРГА



С.ОЧИР-ЭРДЭНЭ

3150600172